



# ЦАСТАЙ ӨДРҮҮД: ХААЛТЫН КОДУУД

## Кодууд ямар утгатай вэ?

### Код 1: Сургууль, Байгууллагууд хаагдсан (өглөөний 5 цагт мэдээлнэ.)

- Бүх сургууль, байгууллагууд хаагдана. Нэмэлт сургалтууд хаагдана.
- Үйлчилгээний ажилтнууд тогтсон цагтаа тайлагнана; Хамгаалагчид өглөөний 6 цагт тайлагнана.
- Сургууль болон сургуулийн талбайд зохиогдох бүх үйл ажиллагаа, хээрийн аяллууд, хөтөлбөрүүд цуцлагдана.

### Код 2: Хожуу нээгдэх—2 цагийн дараа (оройн 18 цагт эсвэл өглөөний 5 цагт мэдээлнэ.)

- Бүх сургууль, байгууллагууд 2 цагийн дараа нээгдэнэ. Нэмэлт сургалтууд 2 цагийн дараа нээгдэнэ.
- Үйлчилгээ/хамгаалалт/хүнсний үйлчилгээний ажилтнууд цагтаа тайлагнана. Бусад ажилтнууд ердийнхөөсөө 2 цагийн дараа тайлагнана.
- Өглөөний автобуснууд 2 цагийн дараа үйлчилнэ. Өглөөний талбайн аяллууд цуцлагдана.
- Сургуулиуд ердийн тардаг цагтаа тарна. Хуваарийн дагуу Эрт Тараах Өдөр: Сургууль бүтэн өдөр хичээллэхгүйгээр тарна.

### Код 3: Эрт Хичээл Тарах (өглөөний 11:30 цагт мэдээлнэ.)

- АНС-ийн бүх сургуулиуд зарласан цагийн дагуу эрт тарна. Нэмэлт сургалтуудыг 16 цагт тараана.
- Үдээс хойшхи автобуснууд хичээл тарсны дараа бууна.
- Үйлчилгээ/хамгаалалтын ажилтнууд хэвийн ээлжээр ажиллана.
- Сургууль болон сургуулийн талбайд зохиогдох үдээс хойшхи/оройн бүх үйл ажиллагаа, тоглоомууд, багийн дасгал, хээрийн аяллууд, насанд хүрэгчдийн хичээлүүд, хөтөлбөрүүд цуцлагдана.

### Код 4: Оройн үйл ажиллагаануудыг цуцлах (өглөөний 11:30 цагт мэдээлнэ.)

- АНС-ийн бүх сургуулиудын сургууль болон сургуулийн талбайд зохиогдох хичээлээс гадуурх үйл ажиллагаа, тоглоомууд, багийн дасгал, хээрийн аяллууд, насанд хүрэгчдийн хичээлүүд, хөтөлбөрүүд зэрэг хичээлийн дараах болон оройн бүх үйл ажиллагаа цуцлагдана.
- Нэмэлт сургалтуудыг оройн 18 цагт тараана.

### Код 5: Амралтын өдрүүдийн үйл ажиллагаануудыг цуцлах (оройн 18 цагаас өмнө мэдээлнэ.)

- АНС-ийн бүх барилгууд хаагдаж, амралтын өдрүүдэд сургууль болон сургуулийн талбайд зохиогдох хичээлээс гадуурх үйл ажиллагаа, тоглоом, багийн дасгал, хээрийн аяллууд, насанд хүрэгчдийн хичээлүүд, хөтөлбөрүүд зэрэг бүх үйл ажиллагаа цуцлагдана.

### Мэдээллийг доорхи сувгуудаас авна уу:

APS School Talk: [apsva.us/schooltalk/](https://apsva.us/schooltalk/)

APS Website: [apsva.us](https://apsva.us)

Олон нийтийн Сүлжээ

- Facebook: [/ArlingtonPublicSchools](https://www.facebook.com/ArlingtonPublicSchools)
- Twitter: [/APSVirginia](https://twitter.com/APSVirginia)
- Instagram: [/APSVirginia](https://www.instagram.com/APSVirginia)

Орон нутгийн ТВ мэдээний сувгууд

Усан сангийн үйл ажиллагаа: [apsva.us/aquatics](https://apsva.us/aquatics)

Мужийн үйл ажиллагаа: [arlingtonva.us](https://arlingtonva.us)



**Arlington  
Public  
Schools**